

БУУРАЛ ГАНДБАДРАА (VERONICA INCANA L) УРГАМАЛ ОРСОН ЭМИЙН ЖОРУУДЫГ МОНГОЛ ЭРДЭМТДИЙН ЭРТНИЙ СУДАР НОМООС ТОГТООХ НЬ

Э.Сансархуяг¹, Т.Ариунжаргал², Д.Тунгалаг³,
Э.Сэлэнгэ⁴, Г.Одонтуяа⁵, Ш.Болд⁶,
^{1,2,3,4,5}ЭЗШУИС, ⁶МАУА

Abstract

ELUCIDATING THE USES OF THE PLANT VERONICA INCANA FROM THE ANCIENT MEDICAL BOOKS

Sansarkhuyag.E¹, Ariunjargal.T², Tungalag.D³,
Selenge.E⁴, Odontuya.G⁵, Bold.Sh⁶
Mongolian University of Pharmaceutical Sciences^{1,2,3,4,5}
Mongolian Academy of Medical Science⁶

Background

In 2011-2020, WHO approved the Global Strategy for Traditional Medicine. The strategy states that "The trend of using traditional medicine and alternative medicine as a source and resource for health care is expanding worldwide."

In this regard, it is important to develop a policy and methodology to develop a proper combination of traditional and modern medicine. Also, there are demands to study and solve the problems of ensuring the safe, effective, quality, availability, and appropriate use of medicines and treatments.

Purpose

Finding traditional medicinal recipes containing the herb *Veronica incana* L from the ancient Mongolian medical books written by famous Mongolian scientists Jambalchoizhidanzanperenlei, Luvsandorj, and Jigmeddanzanjamts.

Research materials and methods

1. Research materials: Jambalchoijidanzanperenlei. gso rig bstan bcos mtha' dag gi snying po rnam phyogs gcig tu bsdus pa man ngag rin chen 'byung gnas bzhugs so. Wooden printing block with Tibetan script. Luvsandorj. sman sbyar tshad kyi skor rnam che long tsam phyogs gcig tu bkod ba kun phan bdud rtsi'i snying bo zhes bya ba bzhugs so). Wooden printing block with Tibetan script. Jigmeddanzanjamts. rgya bad mkhas grub du ma'i gzhung lugs dam pa gong ma rnam kyi man ngag zhal shes lag len myong grub gnad don gnyen po ngo sprod mdzub tshugs dmar khrid kyi bkod pa mthong ba don gsal dga' byed snying po'i rnam gsal bzhugs so. Wooden printing block with Tibetan script.

2. Research methods

Methods of textual analysis for ancient books and checklist methods were used in the study.

Conclusion

Medicinal recipes containing the herb *Veronica Incana* L were sampled from the ancient medical books surveyed. There are 6 recipes in the book of Jambalchoijidanzanperenlei, 3 recipes in the book of Luvsandorj, and 2 in the book of Jigmeddanzanjamts, a total of 11 ingredients. In general, these ancient medical books had a significant impact on the development of traditional Mongolian medicinal prescriptions. Therefore, even today, these works are still important in the theory of pharmaceutical composition and the practice of drug therapy.

Keywords: traditional medicine, *Veronica Incana* L, Mongolian scientists, medicinal recipes

Оршил

Монголд бурхны шашин жинхэнээр дэлгэрснээс хойших зохиолууд нь уламжлалт анагаах ухааны түүхэн хөгжилд давтагдашгүй ул мөрөө үлдээжээ. Ялангуяа Ламын гэгээн Лувсанданзанжанцаны таван зохиол, Сүмбэ хамба Ишбалжирын “Дөрвөн рашаан”, Миндол номун хан Жамбалчойжиданзанпэрэнлэйн “Увдисын далай”, Лувсанчойнпилын “Эмийн гол судруудаас хэсэгчлэн авч нэгэн зүгт найруулж энхрийлэн хураасан зүрхний зэндмэнэ эрдэнэ”, Лувсандорж (Сумади бажраняна) Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай, Жигмэдданзанжамцын “Үзэгсдийн баясгалан”, Чойжамцын “Анагаах ухааны олон төрлийн гол номуудаас хураасан рашааны зүрхэн халуун, хүйтний энэлгийг арилгагч маш гайхамшигт хуримын сан” зэрэг Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын хөгжилд онцгой нөлөө үзүүлсэн бүтээлүүд буй бөгөөд өнөөдөр ч уг бүтээлүүд эм найрлагын онол, эмчилгээний практикт чухал ач холбогдолтой хэвээрээ байна 1.

Хорин нэгдүгээр зууны Монголын уламжлалт анагаах ухааны эм зүй, эм судлалын хөгжлийн үндэс нь өмнөх үеийн эмч, маарамбуудын бүтээн туурвисан анагаах ухааны эртний ном, судруудыг уншиж судлах, уг номуудад байгаа практик хэрэглээ нь өндөр боловч бага судлагдсан эмчилгээний зарим аргын орчин цагийн шинжлэх ухааны үндсийг тогтоох, гүнзгийрүүлэн ойлгох, тэдний гарын авлагын гүн утгыг оновчтой тайлбарлахад оршиж байна.

Үүнийг шийдвэрлэхэд чухал түлхэц өгөх судалгааны нэгэн чиглэл нь уламжлалт анагаах ухааны үндсэн сурах бичиг “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндэс” товчлоод “Анагаах ухааны дөрвөн үндэс”

судрын нарийвчлан судлах, заан сургах, түүний тайлбар зохиолуудын агуулга, хэрэглээг нарийвчлан тогтоох судалгаа өнөөг хүртэл хийдэхгүй байсаар буй.

2011-2020 онд ДЭМБ-аас Уламжлалт анагаах ухааны талаар баримтлах дэлхийн стратегид “Уламжлалт анагаах ухаан, алтернатив анагаах ухааныг эрүүл мэндийн тусламжийн нэг эх сурвалж, нөөц болгон ашиглах хандлага дэлхий нийтээр өргөжиж байна. Үүнтэй холбоотойгоор уламжлалт болон орчин цагийн анагаах ухааныг зүй зохистой хослуулан хөгжүүлэх бодлого, арга зүй боловсруулах, эм, эмчилгээний аюулгүй, үр дүнтэй, чанартай, хүртээмж, зохистой хэрэглээг хангах асуудлыг судлан шийдвэрлэх шаардлагууд амьдралаас дэвшигдэн гарч байна” 2 хэмээн тодорхойлсон байдаг.

Судалгааны ажлын зорилго

Буурал гандбадраа (Veronica Incana L) ургамал орсон эмийн жоруудыг уламжлалт анагаах ухааны алдартай эрдэмтэд Жамбалчойжиданзанпэрэнлэй, Лувсандорж (Сумадибажраняна), гэвш Жигмэдданзанжамц нарын эмийн судар номоос олж тогтоох.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга

1. Судалгааны хэрэглэгдэхүүн

- Жамбалчойжиданзанпэрэнлэй. Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарахын орон хэмээх оршивай (gso rig bstan bcos mtha' dag gi snying po rnam phyogs gcig tu bsdu pa man ngag rin chen 'byung gnas bzhuugs so). Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

- Лувсандорж (Сумади бажраняна) Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай (sman sbyar

tshad kyi skor nams che long tsam phyogs gcig tu bkod ba kun phan bdud rtsi'i snying bo zhes bya ba bzugs so). Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

- Гэвш Жигмэдданзанжамц. Энэтхэг, Төвөдийн мэргэдийн номлол, дээдсийн аман сургаал, туршлага, өвчин адыг эмчлэх гарын авлага, гол удирдамж үзвээс утга нь тодрон оюуныг машид баясгагч хэмээх оршивай (rgya bad mkhas grub du ma'i gzhung lugs dam pa gong ma nams kyi man ngag zhal shes lag len myong grub gnad don gnyen po ngo sprod mdzub tshugs dmar khrid kyi bkod pa mthong ba don gsal dga' byed snying po'i nram gsal bzugs so) Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

2. Судалгааны арга

- Эх зохиол судлах арга

Аливаа нэгэн судалгааны ажлыг хийхэд хамгийн түрүүнд хэрэглэгддэг арга нь эх зохиолыг судлах арга юм. Бид эрт цагийн маарамба, эмч, эрдэмтэн мэргэдийн бичиж туурвисан судар ном зэрэг мэдээллийн эх сурвалжтай ажиллах үедээ уг аргыг ашиглав.

- Харьцуулах арга

Харьцуулах гэдэг нь нэг үзэгдэл юмс нөгөө үзэгдэл юмсаас юугаараа ялгаатай, юугаараа адил төстэй болохыг танин мэдэж, тэдгээрийн нийтлэг ба онцлог шинжийг нээн харуулах боломж олгодог. Бид энэхүү аргыг ашиглан Буурал гандбадраа (Veronica Incana L) орсон эмийн эртний судар номын мэдээллийг нэгтгэн дүгнэх, харьцуулан судалж ялгаатай, төсөөтэй талыг тогтооход ашигласан.

- Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга

Сурвалж бичгийн доторх Буурал гандбадраа (Veronica Incana L) ургамал орсон эмийн

жоруудыг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэхэд ашиглав. Магадлан жагсаах арга нь судлагууныг төрөлжүүлж ангилах, мэдээллийг цуглуулахад хялбар, үнэлгээний эхний шатны ажлыг гүйцэтгэх, төлөвлөсөн нийт ажлыг урьдчилан харах, цахим санд оруулахад зохимжтой, хялбар байдаг.

Судалгааны ажлын үр дүн

Бид Буурал гандбадраа (Veronica Incana L) ургамал орсон эм найрлагын түүврийг хийх судар, эх хэрэглэгдэхүүнээр Миндил номун хан Жамбалчойжиданзанпэрэнлэй, Лувсандорж (Сумади бажраняна), гэвш Жигмэдданзанжамц нарын бүтээлийг гол болгон сонгон авсан. Учир нь Миндил номун хан Жамбалчойжиданзанпэрэнлэйн номонд монгол эм, маарамба, эрдэмтдээс хамгийн өргөн хүрээтэй тооны хувьд хамгийн их (2528 жор) найрлага багтаасан³, Лувсандорж (Сумади бажраняна)-ийн эмийн ном бол барлагдсанаасаа хойш Ар Монголчуудын дунд хамгийн өргөн хэрэглэгддэг эмийн жорын ном болсон бөгөөд төгсгөлийн үгэндээ “Над мэтийн оюун дорой нэгэнд элдэв эмийн найрлага эрхгүй хэрэг болох үед олон судрыг унших зав чөлөөгүй тулсан цагт их тустайг санаж, гараар бичвэй” гэж⁴ бичсэн нь хэр зэрэг үнэ цэнтэй ном болох нь харагдаж байна. Тэрбээр номын төгсгөлийн үгэндээ:

*Эрдэмтэн мэргэдийн бүтээсэн үндсийн
тайлбараар*

*Энэтхэг, Төвөдийн хэсэг бусаг найрлагыг
түүвэрлэн*

Эвлүүлж мунхаг би цаасанд буулган

*Эмхэтгэж найруулан зохиож нийтлэв гэсэн
байдаг⁵.*

Гэвш Жигмэдданзанжамцын бүтээлийг судалгаанд авсан учир нь өнөөгийн БНХАУ-

ын ӨМӨЗО-ны Монгол эмнэлэгт хэрэглэж байгаа монгол эмийн жорын авлагын Жигмэдданзанжамцын номноос ирсэн байх бөгөөд уг номонд Энэтхэг, Төвөдийн түүнчлэн Хятадын мэргэдийн эмийн жороос олонтоо авсан байдаг⁶. Бид бүх жорын нэрийг монгол хэлээр орчуулж, зарим жорыг нэргүй шууд бичсэнийг тэр хэвээр нь буулгалаа.

1. Жамбалчойжиданзанпэрэнлэй. Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарахын орон хэмээх оршивай (gso rig bstan bcos mtha' dag gi snying po rnam phyogs gcig tu bsdu pa man ngag rin chen 'byung gnas bzhugs so) сударт Буурал гандбадраа орсон дараах эм найрлага байна. Үүнд:

1. Цагтаа үхсэн тасын толгой, чулуун эм бүхний эрхэм мөнгөн чулуу *ལྷག་བྱ་མིག* хувь тэнцүү үхрийн аргалд шатааж талхыг нь нүдэнд түрхвэл тастай адил нүдтэй болно хэмээн сударт номлов. Үхсэн хар могойн толгойн дотор мөнгөн чулуу *ལྷག་བྱ་མིག* тостой хольж утааг алдуулалгүй шатаасан үнсийг зүлгэн хүж *ལྷ་མོ* гандбадраатай *གན་རྩ་བ* хамт нягт талхдсан талхаар бүрэлзэх нүдний өвчнийг арилгах болно. Нүдний цөцгий бүлтрэхээс бас сэргийлж чадна.

2. Шараас болсон бүрэлзэх өвчинд эмийн эрхэм шанц *རྩ་བ* чихэр өвс, 2 зүйлийн ранэ *ར་མཉེ* 2 зүйлийн шомоса *ཤོ་མོ* хавтгай мон буурцаг, хайрслал мон буурцаг, санзи *བཟུང་མེ* хужир *ཁྲ་* *བ་ཀ* гурван үр, эдгээр эмийн зүйл бүгдийг нягт талхадсан талхыг тосны шөлөнд тавьж буцалгаад өнө удаан шүтүүлсний дараа чихэр, дүржид *དུར་ཕྱིད* сүгмэлийг балтай найруулж туулгана. Гандбадраа *གན་རྩ་བ* удвал, чихэр өвс, гавар, модон хөвөнгийн цоморлог *ན་ག་བཟུང* зос чулуу *བཟུང་ལྷག་མིག* нягт талхдан нүдэнд түрхвэл шарын бүрэлзэх өвчинд хоцроолгүй туслах болно.

3. Шүдний чигихад яргуй *ལྷ་ཀྱུ* жац давс *ཆུ་ཚོ* повариг түрхэж, шүд буйл хавдвал шар гаа, лаган, зод *བཙོད* хонлин, гандбадраа *གན་རྩ་བ* балтай найруулж түрхэнэ. Буйл хавдаж шалбарахад игүүшин, заар, баавгайн цөс гурвыг цэвэр усанд дэвтээж дахин дахин амыг зайлуулбал тустай. Эсвэл сэндэнгийн хандны түрхлэг *ཁྱི་ལ་མཐོག* алтан өнгөт арүр, хач гүргэм, баавгайн цөс, башгыг *བ་ཤ་ཀྱུ* үнэрт усанд дэвтээж ам дүүрэн оочлуулан гадагш асгуулна.

4. Эсвэл баавгайн цөс, энгэсэг, башга *བ་ཤ་ཀྱུ* жилж, хонлин, шумхан *ཁྱི་ལ་མཐོག* чихэр, тостой найруулж ооч дүүрэн уулган хамрын эмийг өгнө. Лаган жэрү, бор гаа *བཟུང་མེ* гурван үр, живзийг *འཛིན་མེ* балтай найруулж ооч дүүрэн уулгавал тусална. Жэрү, руда, лаган, шудаг, зод *བཙོད* гандбадраа *གན་རྩ་བ* хонлин, шар гааг дэвтээж ооч дүүрэн оочлуулна.

5. Мөнгөн ус-25

Голлогч нь номхотгосон мөнгөн ус, түүний дээр зургаан сайн, заар, гүгэл, шудаг, хүхэр, өмхий давирхай, доод гурван үр, бөөрөн шош, жац давс *ཆུ་ཚོ* гандбадраа, шар усны гурван эм, руда, барагшин нэмж нягт талхдан чихрээр найруулж үрэл хийж, лидэр, сэндэнгийн шөлөөр даруулж өгнө. Тус эрдэм нь саа өвчин, уяман өвчин, бэтэг, усан хаван, хор өвчин, сахуу, боом, шар ус, арьсны өвчин, үү, ям, хэрх, тулай, хөлийн бам өвчин, ялангуяа бөөрний хэрх өвчинд маш тусална.

6. Сүгмэлийн үрэл

Гавирын хальс, сүгмэл, гандхабхадра¹ *གན་རྩ་བ* *ཁྱི་ལ་མཐོག* гурав тус бүр нэг цэн, бивлин таван цэн, цагаан чихэр, үзэм, хасарваань тус бүр хоёр цэнг нягт талхдаад зөгийн балаар үрэлдэж Сүгмэл үрэл хэмээх бөгөөд үүнийг шүтүүлбэл ханиад, амьсгал амаргүй, толгой эргэх, зогьсуулах, дур булгих, уушгины өвчин

¹ Гандбадраа, гандибадраа, Буурал гандбадраа. (Veronica incana L)

ялангуяа барагдуулагчийг арилгана⁷.

2. Лувсандорж (Сумади бажраняна) Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай (sman sbyar tshad kyi skor nams che long tsam phyogs gcig tu bkod ba kun phan bdud rts'i'i snying bo zhes bya ba bzhugs so) сударт буурал гандбадраа орсон дараах эм, жорууд байна Үүнд:

1. Зандан, гүргэм, сүгмэл, гурван үр, жадри, шар мод, зул мод, гурван халуун, **гандбадраа**, манын үндэс, тэмээн хөх (dug mo nyung), бүшэлз, цагаан гич, арц мод, хятад хүж өвс, бирянгуу, емон цагаан цэцэг, рүда, хонлин, цагаан бон-а, архины шаар, алтан хүхэр, үхэр, адуу, илжиг, ямаа, хонь сэлтийн шээс нугуудыг хуучин тосонд найруулсан шүүсийг залбирлын тосон эм хэмээх бөгөөд үүнийг идэх ба түрхэх, хамарт хийвээс адыг түргэн тонилгоно.

2. Дали, емон, **гандбадраа**, манын үндэс, нагаагэсэр, бүсбагэсэр, бүшэлз, дуца, явагцар, гурван сайн, бурмыг тос, архинд шалзартал чанаад, үрэл болгон бөөгнөрсөн далийн шингээгч үрлээр усан хаванг дарна.

2. Дали, емон, повари, гаа, цулхар, бүшэлз, хонлин сайхан үнэрт дөрөв; шинца, сүгмэл, **гандбадраа**, манын үндэс хийгээд гэсэр буюу жуган, бурмын үрлээр элэг, бэтэг, амьсгал амаргүй болох, ханиах, шамбрам, өтгөн хатахыг дарна. Зарим нэг найрлагын хэмжээнд даль, емон тус бүр хоёр цэн, гаа, повари тус тус гурван цэн, бусдыг нэг цэн өгч болно хэмээжээ⁸.

3. Гэвш Жигмэдданзанжамц. Энэтхэг, Төвөдийн мэргэдийн номлол, дээдсийн аман сургаал, туршлага, өвчин адыг эмчлэх гарын авлага, гол удирдамж үзвээс утга нь тодрон оюуныг машид баясгагч хэмээх оршивай (rgya bad mkhas grub du ma'i gzhung lugs dam

pa gong ma nams kyi man ngag zhal shes lag len myong grub gnad don gnyen po ngo sprod mdzub tshugs dmar khrid kyi bkod pa mthong ba don gsal dga' byed snying po'i nram gsal bzhugs so) номонд яг Гандбадраа голлон орсон 2 жор байна.

1. Гандбадраагийн туулга

Өчүүхэн хошуут арүр 1 цэн, агширга 2 цэн, сөд ороонгуйн ханд 2 цэн, мана 2 цэн, **гандбадраа** 3 цэнгээр найруулна. Энэхүү туулгаыг үнээний шээсээр ташуурдаж өгвөөс туулгаж арилгана.

2. Гандбадраа-6

Гандбадраа 1 цэн, сахал өвс 1 цэн, гадүр 1 цэн, царсны үр 1 цэн, гаа 1 цэн, үсү 1 цэн, эдгээрийг бурамтай найруулж уулгаваас суулгах өвчинг арилгана хэмээн бичжээ⁹.

Хэлцэмж

Жамбалчойжиданзанпэрэнлэй “Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарахын орон хэмээх оршивай” номонд Буурал гандбадраа орсон 6 жор байна. Үүнээс Мөнгөн ус-25, Сүгмэлийн үрэл гэсэн нэр бүхий найрлага 2, үлдсэн 4 нь эмийн оноосон нэр байхгүй, нүдний өвчнийг анагаах 2, шүдний өвчнийг анагаах 2 жор тус тус байна. Мөнгөн ус-25 жор өнөөгийн уламжлалт анагаах ухааны практикт хэрэглэдэг. Бусад нь хэрэглэгдэхгүй байна.

Лувсандорж (Сумади бажраняна) “Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай” номоос түүсэн 3 жор гурвуулаа жорын нэргүй байна. Эдгээр нь адын өвчин, хаван өвчин, элэг, бэтэг, амьсгал амаргүй болох, ханиах, шамбрам, өтгөн хатахыг анагаах эмүүдээс бүрдэнэ. Өнөөгийн практикт аль ч хэрэглэгдэхгүй байна. Лувсандоржийн энэхүү эмийн судар нь монгол хүний төвөд хэлээр бичсэн бүтээл

бөгөөд БНХАУ-ын ӨМӨЗО-д ч, манай улсад ч урьд өмнө нь монгол хэлээр орчуулагдаж байгаагүй маш сонирхолтой бүтээл юм. Төгсгөлийн үгэндээ:

Үүнийг Го угсааны мэргэдийн сайн номлол хийгээд

Олон эмчийн тэнсэж мэдсэн найрлагын хэмжээг

Уялга үсэг, элдэв зүйл бүхнээс хураангуйлж зохиов

Үүнээс өөрөө урласан гутамшиг үгүй буюу хэмээн сэтгэвэй

Тийн атал би бээр шинийг судалж, доодсийн дүр байдалд

Эндүүрэл ташаарал гарваас мэргэд засан зохиомуй

Сайн хувь гарваас түүгээр зорчигч бүхэн

*Насад өвчингүй, амгалан амьдрах болтугай гэж өгүүлсэн байдаг*¹⁰.

Гэвш Жигмэдданзанжамцын “Энэтхэг, Төвөдийн мэргэдийн номлол, дээдсийн аман сургаал, туршлага, өвчин адыг эмчлэх гарын авлага, гол удирдамж үзвээс утга нь тодрон оюуныг машид баясгагч хэмээх оршивай” сударт Буурал гандбадраа орсон 2 жор буй. Энэ 2 жор нь хоёулаа Гандбадраагаар нэрлэгдсэн нэг нь туулга, нөгөөх нь суулгахыг зогсоох эм.

Жамбалчойжиданзанпэрэнлэй, Лувсандорж (Сумадибажраняна), гэвш Жигмэдданзанжамц нарын бүтээлд байгаа Гандбадраа орсон жорууд өмнө нь судлагдаж байгаагүй, судалвал зохих найрлагууд төдийгүй цаашид практикт хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Буурал гандбадраа (Veronica Incana L)

ургамал орсон эмийн жоруудыг судалгаанд авсан гурван эх сурвалжаас түүвэр хийхэд Жамбалчойжиданзанпэрэнлэйн номонд 6, Лувсандорж (Сумадибажраняна)-ийн номонд 3 жор, гэвш Жигмэдданзанжамцын номонд 2 нийт 11 найрлага байна. Ерөнхийдөө эдгээр судар, номууд Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын хөгжилд чухал нөлөө үзүүлсэн төдийгүй өнөөдөр ч уг бүтээлүүд эм найрлагын онол, эмийн эмчилгээний практикт ач холбогдолтой хэвээрээ байна.

Ном зүй

1. Болд Ш., Цэрэнсодном Д., Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. 2014, 21
2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. Номхон далайн баруун эргийн бүсийн хороо. WPR/RC62/6, 2011 оны 7-р сарын 28-ны өдөр
3. Жамбалчойжиданзанпэрэнлэй. Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарахын орон хэмээх оршивай (gso rig bstan bcos mtha' dag gi snying po rnam phyogs gcig tu bsdu pa man ngag rin chen 'byung gnas bzhu gs so). Модон барын төвөд судар
4. Лувсандорж (Сумадибажраняна) Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай (sman sbyar tshad kyi skor rnam che long tsam phyogs gcig tu bkod ba kun phan bdud rtsi'i snying bo zhes bya ba bzhu gs so). Модон барын төвөд судар
5. Лувсандорж (Сумадибажраняна) Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай (sman sbyar tshad kyi skor rnam che long



tsam phyogs gcig tu bkod ba kun phan bdud
rtsi'i snying bo zhes bya ba bzhugs so).
Модон барын төвөд судар

6. Гэвш Жигмэдданзанжамц. Энэтхэг, Төвөдийн мэргэдийн номлол, дээдсийн аман сургаал, туршлага, өвчин адыг эмчлэх гарын авлага, гол удирдамж үзвээс утга нь тодрон оюуныг машид баясгагч хэмээх оршивай (rgya bad mkhas grub du ma'i gzhung lugs dam pa gong ma rnam kyi man ngag zhal shes lag len myong grub gnad don gnyen po ngo sprod mdzub tshugs dmar khrid kyi bkod pa mthong ba don gsal dga' byed snying po'i rnam gsal bzhugs so) Модон барын төвөд судар

7. Жамбалчойжиданзанпэрэнлэй. Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарахын орон хэмээх оршивай (gso rig bstan bcos mtha' dag gi snying po rnam phyogs gcig tu bsdu pa man ngag rin chen 'byung gnas bzhugs so). Модон барын төвөд судар

8. Лувсандорж (Сумади бажраняна) Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай (sman sbyar tshad kyi skor rnam che long tsam phyogs gcig tu bkod ba kun phan bdud rtsi'i snying bo zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар

9. Гэвш Жигмэдданзанжамц. Энэтхэг, Төвөдийн мэргэдийн номлол, дээдсийн аман сургаал, туршлага, өвчин адыг эмчлэх гарын авлага, гол удирдамж үзвээс утга нь тодрон оюуныг машид баясгагч хэмээх оршивай (rgya bad mkhas grub du ma'i gzhung lugs dam pa gong ma rnam kyi man ngag zhal shes lag len myong grub gnad don gnyen po ngo sprod mdzub tshugs dmar khrid kyi bkod pa mthong ba don gsal

dga' byed snying po'i rnam gsal bzhugs so)
Модон барын төвөд судар

10. Лувсандорж (Сумади бажраняна) Эмийн найрлагын хэмжээний аймаг нуугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туслах рашааны шим хэмээх оршивай (sman sbyar tshad kyi skor rnam che long tsam phyogs gcig tu bkod ba kun phan bdud rtsi'i snying bo zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
АУ-ы доктор, профессор З.Ариунаа